

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Я.ЖАРГАЛЦЭЦЭГИЙН 2025 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар

Нэгжийн нэр: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт (70 оноо)
1	2	3	4
1.	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	96.5	67.5

1. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хариуцсан чиг үүргийн хүрээнд зохион байгуулагдах сургалт, уулзалт, хэлэлцүүлэгт хамрагдах	100	15.0
2.	Удирдлагын манлайлал чиглэлээр сургалтад хамрагдах	100	15.0
3	Үндэсний бичгийн мэдлэг чадвараа сайжруулах, компьютерын цэс суулгаж албан хэрэгцээндээ ашиглаж хэвших	90	14.0
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			14.7

2. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	15.0
2.	Удирдан зохион байгуулах	15.0
3.	Асуудал шийдвэрлэх	14.5
4.	Манлайлах	15.0
5.	Багаар ажиллах	15.0
6.	Харилцаа	15.0
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		14.9

3. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)	67.5
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	14.7
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	14.9

4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	—
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо		97.1

Үнэлгээ өгсөн:

Төсвийн шууд захирагч

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ш.ЭРДЭНЭБАТ/

2025 оны 12 сарын 10 өдөр

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

Нэгжийн дарга:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Я.ЖАРГАЛЦЭЦЭГ

2025 оны 12 сарын 10 өдөр

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025.12.10

Есөнбулаг

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хэрэгжилт	Хувь
НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ							
Зорилт 1.1. Монгол Улсын сайдуудтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангана.							
1.1.1	Монгол Улсын Ерөнхий сайдын батламжийн биелэлтэд хяналт тавих, нэгтгэн тайлагнах	-	Тайлагналтын тоо	1	1	Монгол Улсын Ерөнхий сайдын батламжаар хүлээлгэсэн үүрэг даалгаврыг холбогдох хэлтсүүдэд картлан хүргүүлсэн. Хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор багтаан хүргүүлнэ.	100
1.1.2	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргатай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, нэгтгэн тайлагнах	-	Тайлагналтын тоо	2	2	Төрийн зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээний 2025 оны хагас жилийн хэрэгжилтийг нэгтгэн 60,6 хувьтай биелэлтийг ЗГХЭГ-т хүргүүлсэн. Жилийн эцсийн тайланг 12 дугаар сарын 15-ны дотор хүргүүлэхээр бэлтгэж байна.	100
1.1.3	Монгол Улсын Шадар сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, нэгтгэн тайлагнах	-	Тайлагналтын тоо	1	1	Төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар тайлагнахаар гэрээнд тусгасан байдаг. Жилийн эцсийн тайланг 12 дугаар сарын 15-ны дотор хүргүүлэхээр бэлтгэж байна.	100

Зорилт 1.2. Аймгийн бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлнэ.							
1.2.1	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, нэгтгэн тайлагнах	-	Тайлагналтын тоо	4	4	2025 оны 12-р сарын байдлаар АИТХ-с хяналтад авсан 25 тогтоол байгаа бөгөөд үүнээс: Хэрэгжсэн 18, хэрэгжээгүй 4, хугацаа болоогүй 3 тогтоол байгаа бөгөөд хэрэгжилт 81,8% хувьтай байна.	100
1.2.2	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, нэгтгэн тайлагнах	-	Тайлагналтын тоо	2	2	Аймгийн Засаг даргын 2024-2028 оны арга хэмжээний төлөвлөгөөний заалтыг холбогдох хэлтэс, сум, агентлагт картлан хүргүүлж хэрэгжилтийг ханган ажиллагаа. Хагас жилийн биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нэгтгэсэн. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны хэрэгжилт 93,9 хувьтай үнэлэгдсэн. 2025 оны 7 сараас хойш уг ажил БОНХОБТХ-г чиг үүргийн дагуу шилжсэн/	100
1.2.3	Стратеги төлөвлөгөө боловсруулан батлуулах, хэрэгжилтэд хяналт тавьж, нэгтгэн тайлагнах	-	Баталсан стратеги төлөвлөгөө, тайлагналтын тоо	0	1	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний батлагдснаас хойш 60 хоногийн дотор батлуулахаар хуульд заасан байдаг. Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг байгуулагдаж, стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулан, Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний батлагдсан төлөвлөгөөтэй уялдуулан Стратеги төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.	100

						/2025 оны 7 сараас хойш уг ажил БОНХОБТХ-т чиг үүргийн дагуу шилжсэн/	
1.2.4	Сарын ажлын товч тайланг хэлтсүүдээс авч нэгтгэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүлэх		Тайлангийн тоо	10	12	Аймгийн сарын ажлын 2025 оны 1,2,3,4,5,6,7,8,9,10,11 дүгээр сарын товч тайланг хэлтэс, сүм, агентлагаас нэгтгэн 3ГХЭГ-т khongorzul@cabinet.gov.mn цахим хаягаар заасан хугацаанд хүргүүлсэн. Тасарсан, хугацаа хоцорсон тайлан байхгүй.	100

Зорилт 1.3. Цахим хөгжил, мэдээлэл технологийн чиглэлээр

1.3.1	Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулах	-	Сургалтын тоо	-	5	Иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Төрийн цахим шилжилт, үйлчилгээний хэлтэстэй хамтран 8 удаагийн сургалт, зөвлөгөөн, уралдаан тэмцээнийг зохион байгуулсан. Үүнд: Хурдан СУР-2025, TechWeek-2025, Хиймэл оюун ухааны хэрэглээ, нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэхэд уулзалт, цахим дархлаажуулалтын аян, Digital-first-2025, бүх нийтийн цахим ур чадвар дээшлүүлэх 5-р аян, Хантайшир СУР-2025-CS2 зэрэг тэмцээн, уралдаан сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулан ажилласан. Мөн 13 сумд зорилтот бүлгийн иргэд, төрийн албан хаагчдад зориулсан сургалтыг зохион байгуулсан ба нийт 6683 иргэн хамрагдсан.	100
1.3.2	Тамгын газар, архивын тасгийн компьютер, тоног төхөөрөмжийг шинэчлэх	-	Тоног төхөөрөмжийн тоо	-	10	Тамгын газрын 55 албан хаагчаас хэрэгцээ, шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгаа авч 3 хүнд	100

						компьютер, хурдан сканер-3, принтер, зургийн аппарат, хэлтсийн дарга нарыг таблетээр хангах ажилд нийт 43,030 сая төгрөгийн техник тоног төхөөрөмжөөр ханган ажиллах орчныг бүрдүүлсэн. Төрийн албаны салбар зөвлөлийн 20 компьютерыг шинэчлэн ашиглалтад оруулсан.	
1.3.3	Төрийн байгууллагуудыг shien.gov.mn-д холбох	-	Холбогдсон байгууллага	10	40	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор shien.gov.mn сайтад аймгийн 200 байгууллага бүртгүүлэхээс 196 байгууллагын бүртгэлийг баталгаажуулан хандах эрхийг нээн өгч ажиллаж байна. Shien.gov.mn-д мэдээлэл оруулах, шинэчлэх үүрэг бүхий ажилтнуудыг чадавхжуулах зорилгоор 2025 оны 10 сард 71 байгууллагын төрийн байгууллагын мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтнүүд хамрагдсан.	100
1.3.4	Төрийн байгууллагуудыг gov.mn нэгдсэн системд холбох	-	Холбогдсон байгууллага	5	30	Аймгийн төрийн байгууллагуудад gov.mn нэгдсэн системд бүртгэл үүсгэх, мэдээлэл ирүүлэх тухай албан бичиг хүргүүлсэн. Бүртгүүлж эрх авахаар 48 албан байгууллагуудын бүртгэлийг үүсгэж, заавар зөвлөмж өгч ажиллаж байна.	100
1.3.5	Нийтийн мэдээллийн ил тод байдлыг сайжруулах	-	Хэрэгжилтийн хувь	70	85	Аймгийн хэмжээнд хуулийн хэрэгжилтийг хангаж shien.gov.mn сайтад 200 байгууллага бүртгүүлэхээс 196 байгууллагын бүртгэлийг хийн баталгаажуулж хандах эрхийг нээн, заавар зөвлөгөө өгч байгууллагын үнэлгээг хийн хэвлэн нийтэлж хянан баталгаажуулан ажиллалаа.	90

						Байгууллагын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.	
1.3.6	Орон нутгийн хэмжээнд төрийн үйлчилгээт хүч, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр хүртээмжтэй хүргэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор киоск машиныг нэвтрүүлэх, тоог үе шаттайгаар нэмэгдүүлэх;	-	Киоск машины тоо	3	5	Аймгийн төвд 3, сумдад 18 нийт 22 киоск машин байршуулж иргэдэд төрийн үйлчилгээг цахимаар хүргэж эхэлсэн. 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар иргэд 12166 лавлагаа, мэдээлэл, тодорхойлолтыг киоск машинаас аваад байна.	100
1.3.7	Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ашиглаж буй программ хангамжийг албан ёсны эрхтэй программаар хангах	-	Программ хангамж	-	40	Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын 56 компьютерт, 1 жилийн эрхтэй "kaspecky" вирусны программыг суулгаж программ хангамжийн аюулгүй байдлыг хангаж ажигласан.	100
Зорилт 1.4. Иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг хуулийн дагуу барагдуулж шийдвэрлэлттэд тавих хяналтыг сайжруулна.							
1.4.1	Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт бичгээр, 7048-1111 тусгай дуугараар, хайрцагар, цахим хаягаар, биечлэн ирүүлсэн өргөдөл, гомдлыг цаг тухай бүрт хүлээн авч, ERP системд бүртгэн, шийдвэрлэлтийн хугацаанд хяналт тавих, хугацаа хэтэрсэн өргөдөл гомдолгүй байх	-	Шийдвэрлэлтийн хувь/ Хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн өргөдөл, гомдлын тоо	95,6 хувь	96 хувь	Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 1111 төвөөс шилжин ирсэн, бичгээр болон биечлэн, 7048-1111 утсаар болон аймгийн цахим хуудсаар тус тус өргөдөл, гомдлыг хүлээн авч, ERP төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны нэгдсэн системд бүртгэн баталгаажуулж, холбогдох албан тушаалтанд шуурхай хүргүүлж, шийдвэрлэлттэд хяналт тавьж, хариут иргэдэд мэдэгдэн ажиглаж байна. Аймгийн хэмжээнд нийт 429 өргөдөл, гомдол хүлээн авч, 90,2%-тай шийдвэрлэсэн. 42 өргөдөл гомдол хуулийн хугацаандаа судлагдаж байна. Хугацаа хэтэрсэн болон хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн өргөдөл гомдол байхгүй. Өргөдөл гомдлын тайлан мэдээт улирал бүр нэгтгэн тайланг Засаг даргын удирдлагын зөвлөлийн	96

						хурлаар хэлэлцүүлэн Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлж байна.	
1.4.2	Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах-1111 төвөөс шилжин ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг эрс сайжруулж, хугацааг 2 дахин бууруулах	-	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацаа	30 хоног	15 хоног	Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах-1111 төвөөс нийт 39 өргөдөл хүлээн авч, холбогдох албан тушаалтанд шуурхай хүргүүлж, шийдвэрлэлтэд хяналт тавьж, хариуг иргэдэд мэдэгдэн ажиллаж байна. 34 өргөдөл гомдлыг буюу 87%-ийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн ба 5 өргөдөл, гомдол шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна. Өргөдөл шийдвэрлэлтийн дундаж хугацаа 26 хоног байна.	90
1.4.3	Аймгийн Засаг даргын Тамгын газар, 18 сум, 24 агентлагийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг улирал бүр хүлээн авч, нэгтгэн Засаг даргын Удирдлагын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт заасан хугацаанд хүргүүлэх	-	Хугацаанд нь хүргүүлсэн тайлангийн тоо	4	4	Аймгийн Засаг даргын Тамгын газарт нийт 151 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлснээс 136 буюу 90%-ийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн ба 35 өргөдөл хугацаандаа судлагдаж байна. Хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдол байхгүй.	90
1.4.4	Ижил агуулгын хурээнд ихээр өргөдөл, гомдол ирж буй асуудлуудад дүн шинжилгээ хийж, холбогдох хэлтэс агентлагуудад хүргүүлэн шуурхай арга хэмжээ авах	-	Дүн шинжилгээ хийсэн тайлан	-	1	2025 оны 1 сард Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 2024 онд иргэдээс ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд түүвэрчилсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийн ажилласан. Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 1111-төвөөс шилжин ирсэн 67, аймгийн Засаг дарга түүний тамгын газарт ирсэн 271 өргөдөл гомдол бүртгэгдсэн бөгөөд 94,3 хувьтай шийдвэрлэгдэж, бүрэн шийдвэрлэж хариу өгсөн 63, хугацаа болоогүй 4 өргөдөл гомдол бүртгэгдсэн байна. 2025 онд иргэдээс төрийн албан тушаалтанд ирсэн өргөдөл гомдолд түүвэрчилсэн хяналт-шинжилгээ	100

						Үнэлгээг хийхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	
1.4.5	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг улирал бүр иргэд, олон нийтэд мэдээлэх	-	Олон нийтэд хүргэсэн мэдээний тоо	0	4	Иргэдээс ирсэн өргөдөл гомдлын мэдээг тогтмол улирал бүр шийдвэрлэлтийн тайлан, статистик мэдээллийг нэгтгэн боловсруулж, олон нийтэд ил тод мэдээлэх зорилтын хүрээнд gov-aitai.gov.mn цахим хуудсанд үе шаттайгаар байршуулан ажиллав. Мөн мэдээллийн хүртээмжийг сайжруулах үүднээс тайлангийн бүтэц, агуулгыг нэг мөр болгон, иргэдэд ойлгомжтой байдлаар нийтэлж, ил тод байдлын шаардлагыг ханган ажиллалаа.	100
1.4.6	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдалд хяналт тавьж, хуулийн хугацаанд нь бодитой шийдвэрлэх хэрэгжилтийг хангуулах, мэргэжил арга зүй удирдлагаар хангах	-	Хүргүүлсэн албан бичгийн тоо	0	4	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн архивын хэлтэс, Архивчудын хөгжил, сургалт арга зүйн төв, Хэлний бодлогын салбар зөвлөлтэй хамтарсан архив, бичиг хэрэг хариуцсан ажилтнуудын чадавхжуулах сургалт, Хууль эрхзүйн хэлтээс зохион байгуулсан сумдын ЗДТГ-ын Хууль эрхзүйн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн 2 удаагийн сургалт, сумдын Засаг дарга, ЗДТГ-ын дарга нарын 2 удаагийн уулзалтаар иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандан ирүүлсэн өргөдөл, гомдол түүний шийдвэрлэлтэд	100
Зорилт 1.5. Чадахуйн зарчимд нийцсэн мэргэшсэн албан хаагчдаар төрийн албыг бэхжүүлж, төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж, хөгжүүлнэ.							
1.5.1	Төрийн байгууллагуудаас ирүүлсэн сул орон тооны захиалгыг нэгтгэн, шилжих сэлгүүлэх ажлын байрны жагсаалтыг олон нийтэд нээлттэй мэдээлж сул орон тоог чадахуйн	-	Шилжих сэлгүүлэх ажлын байрны зарын тоо	4	4	2025 онд төрийн байгууллагуудаас ирсэн ажлын байрны сул орон тооны судалгааг нэгтгэн шилжүүлэх сэлгүүлэх зарыг 7 удаа 168 ажлын	100

	зарчим болон шатлан дэвшүүлэх тогтолцоог мөрдүүлэх					байрыг олон нийтэд нээлттэй байршуулсан.	
1.5.2	Төрийн жинхэнэ албаны ерөнхий, тусгай шалгалт болон төсвийн ерөнхийлөн захирагчийн сонгон шалгаруултыг зохион байгуулж, нэр дэвшүүлэх, томилгох үйл ажиллагаанд хяналт тавих	-	Сонгон шалгаруулалт зарласан ажлын байрны тоо	7	8	2025 онд тусгай шалгалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлд 5 удаа нийт 203 сул ажлын байрны захиалгыг хүргүүлэн, сонгон шалгаруулалтыг хуулийн хугацаанд нь явуулж 72 сул ажлын байрыг нөхсөн. Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.7, 33.10 дахь хэсэгт заасны дагуу “Төрийн албаны ерөнхий шалгалт”-ын бүртгэлийг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар бүртгэж, 4 удаа зохион байгуулсан. 2025 оны ерөнхий шалгалтын бүртгэлд нийт 328 иргэн хамрагдаж, шалгалтад 262 иргэн орж, 2025 оны I-IV улирлын ерөнхий шалгалтад нийт 87 иргэн тэнцэж, нөөцөд бүртгэгдлээ.	100
1.5.3	Төрийн жинхэнэ албан хаагчдыг тангараг өргүүлэх ажлыг зохион байгуулна.	-	Тангараг өргүүлэх тоо	3	2	Төрийн албаны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 84 дүгээр зарлигаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ын 2.1, 2.3 дахь заалтын дагуу тангараг өргөх үйл ажиллагааг 2 удаа зохион байгуулж, 2025 онд нийт 51 төрийн жинхэнэ албан хаагч тангараг өргөлөө.	100
1.5.4	Төрийн жинхэнэ албан хаагчдад зэрэг дэв олгох	-	Захирамжийн тоо	11	-	Тайлант хугацаанд ахлах түшмэлийн зэрэг- 25, дэс түшмэлийн зэрэг- 159, туслах түшмэлийн зэрэг-3, нийт 187 төрийн албан хаагчийн зэрэг дэвийг Төрийн албаны тухай хууль, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолын дагуу шинээр олгох, ахиулах	100

					шийдвэрийг аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн Б/30 дугаар захирамжаар гаргасан.	
1.5.5	Аймгийн Засаг дарга болон Тамгын газраас гарах шийдвэрүүдийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж гаргах	Захирамж, тушаалын тоо	150	-	Энэ оны 12 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар хүний нөөцтэй холбоотой 91 захирамж, 120 тушаал, үйл ажиллагаатай холбоотой 80 тушаал гаргаж хэрэгжилтийг ханган ажиллалаа	100
1.5.6	Аймгийн Засаг даргын Тамгын газрын сургалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах;	Хэрэгжилтийн хувь	80 хувь	90%-аас доошгүй	Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025-2028 онд хэрэгжүүлэх сургалтын хөтөлбөрийг 2025 оны А/58 дугаар тушаалаар батлуулан, 2025 онд хэрэгжүүлэх 2 зорилтын хүрээнд 10 заалт төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд Нутгийн хөгжил, бидний зүтгэл төрийн бус байгууллагаатай хамтран ажиллах гэрээ байгуулан 3 удаагийн сургалт зохион байгууллаа. Засгийн газрын зорилтод сургалтад 3, Төрийн албаны зөвлөлийн арга зүйн сургалт зөвлөгөөнд 8, Удирдлагын академийн богино хугацааны сургалтад 1, мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 2, ахлах түшмэлийн сургалтад 2, мэргэжлийн болон бусад байгууллагын сургалтад 19 хүн 29 удаагийн сургалтад хамрагдсан. Нийслэлийн ЗДТГ-аас зохион байгуулсан "Бүтээмж ба Инновац-УВ 2025" харилцан суралцах арга зүйн форумд ХШҮХ-ийн ахлах мэргэжилтэн Э.Буянтөгс "Ажлын байрны эмх цэгц-хялбар тайлагналт"" сэдвээр оролцож Тэргүүн байр эзэллээ.	100

1.5.7	Аймгийн төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг нэгтгэн дүгнэх;		Хэрэгжилтийн хувь, тайлангийн тоо	85 хувь	90%-аас доошгүй	Төрийн албан хаагчдад орон сууцны дэмжлэг үзүүлэх журмыг шинэчлэн боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 08 дугаар тогтоолоор батлуулсан. Төрийн байгууллагуудаас орон сууцны дэмжлэгт хамрагдах хүсэлтэй, шаардлага хангасан төрийн албан хаагчдын материалыг журмын дагуу хүлээн авч, 12 сард дэмжлэгийг олгохоор ажиллаж байна. Эрүүл мэндийн салбарын 80 албан хаагчид тус бүр 10,0 сая төгрөгийн орон сууцны дэмжлэг олгох батламж гардууллаа. Аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн Б/30 дугаар захирамжаар ахлах түшмэлийн зэрэг- 25, дэс түшмэлийн зэрэг- 159, туслах түшмэлийн зэрэг-3, нийт 187 төрийн албан хаагчийн зэрэг дэвийг ахиулах шийдвэр гаргалаа. Удирдлагын академийн чиглүүлэх богино хугацааны сургалтад 16, мэргэшүүлэх дунд 15, мэргэшүүлэх давтан 54, ахлах түшмэл 15, эрхэлсэн түшмэлийн сургалтад 1 хүн хамрагдлаа. Нийт 1754 төрийн албан хаагч мэргэжлийн сургалтад хамрагдсан байна.	90
-------	--	--	-----------------------------------	---------	-----------------	--	----

1.5.8	Аймгийн Засаг даргын Тамгын газарт чанарын менежментийн тогтолцооны стандарт нэвтрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах;		Стандарт нэвтрүүлсэн эсэх	-	1	Аймгийн Засаг даргын Тамгын газарт чанарын менежментийн тогтолцооны стандарт нэвтрүүлэх ажлын хүрээнд байгууллагын чанарын багийг шинэчлэн байгуулж 2025 оны ажлын төлөвлөгөөг батлууллаа. Төлөвлөгөөний хүрээнд албан хаагчдын ажлын байранд үнэлгээ хийж ажилласнаар 3 өрөөнд засвар хийж 4 хүний ширээ шүүгээ, 3 хүнд компьютер, хурдан сканнер-3, принтер, зургийн аппарат хэлтсийн дарга нарыг таблетээр хангах ажилд нийт 43,030 сая төгрөгийн техник тоног төхөөрөмжөөр ханган ажиллах орчныг бүрдүүллээ.	100
1.5.9	Төрийн улс төрийн болон үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулах;		Батлагдсан албан тушаалын тодорхойлолт	-	10-аас доошгүй	Төрийн улс төрийн 3, төрийн үйлчилгээний 5 албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг батлуулан мөрдлөг болгон ажиллаж байна. Төрийн захиргааны 28 албан тушаалын тодорхойлолтод дүн шинжилгээ хийж батлуулахаар төрийн албаны зөвлөлд хүргүүлж, Засаг даргын Тамгын газрын даргын А/55 тушаалаар хэлтсийн дарга нарын 7 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулсан.	100
1.5.10	Байгууллагын албан хаагчдын мэдлэг, мэргэшлэг, ур чадварыг сайжруулах сургалт зохион байгуулах;		Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо	-	4	Байгууллагын албан хаагчдыг чадавхижуулах зорилгоор Нутгийн хөгжил, бидний зүтгэл төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан хувь хүний хөгжлийн чиглэлээр 3 удаагийн сургалтад давхардсан тоогоор 95 албан хаагч хамрагдлаа. Мөн Төрийн албан хаагчдад зориулсан хиймэл оюун ухааны хэрэглээ сургалт,	100

					Хөрөнгийн зах зээлээс төсвийн бүс эх үүсвэр татах, хөрөнгийн зах зээлд хэрхэн оролцох талаарх зөвлөх үйлчилгээ үзүүлэх сургалт, Хууль эрхүйн мэдлэгийн сургалт, Орон нутгийн бэлэн байдлын сургалт зэрэг сургалтуудад албан хаагчид бүрэн бүрэлдэхүүнээрээ хамрагдлаа. Тус байгууллагын 7 албан хаагч БНХАУ, БНСУ-д мэргэжлийн чиглэлээр сургалтад хамрагдлаа.	
1.5.11	Төрийн албаны тухай хууль болон төрийн албаны стандарт, Төрийн албан хаагчдын ёс зүйн хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр сумдын Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс, агентлагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах.	Ажиллах сум, байгууллагын тоо	-	10-аас доошгүй	Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 02 дугаар тушаалаар сумдад үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагууд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж буй байдал, хүний нөөцийн зохицуулалтын хэрэгжилттэй танилцан хяналт шалгалт хийх, албан хаагчдад төрийн албаны шинэтгэлийн талаар мэдээлэл, сургалт зохион байгуулах, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах ажлын хүрээнд 18 сумд хүрч ажилласан. Нийт аймгийн хэмжээд 49 зөрчилтэй томилгоо гарч, зөрчлийг бууруулах зорилгоор 100 гаруй сул орон тооны тусгай шалгалтыг 3 удаа зохион байгуулж, зөрчлийн 33 нь арилгасан. Мөн Дарив, Шарга, Хөхморьт, Цээл сумдын "Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн"-д оролцож, "Төрийн албаны стандарт", "Төрийн албаны шинэтгэл", "Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилт" сэдвээр	100

[illegible]

	1.7.1 Аймгийн Засаг даргын гадаад айлчлал, арга хэмжээний талаар Гадаад харилцааны яаманд мэдэгдэж, чиглэл авч, илтгэх хуудсыг Гадаад харилцааны яаманд хүргүүлнэ.		Авсан чиглэл, хүргүүлсэн илтгэх хуудасны тоо	2	3-аас доошгүй	2025 оны байдлаар аймгийн Засаг дарга Г.Чинбат БНХАУ-ын коммунист намын урилгаар 2025 оны 03 дугаар сарын 24-28-ны өдрүүдэд Бээжин, Гуанжоу хотноо айлчилсан. Айлчлалын зөвшөөрлийг 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 3/365 дугаар албан бичгээр хүссэн. БНХАУ-ын Цонж, Шинжааны Вүжиачу хотуудын урилгаар 04 дүгээр сард айлчлахаар төлөвлөж 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 1/300 албан бичгээр зөвшөөрөл хүссэн. Мөн БНХАУ-ын эрчим хүчний салбарын төлөөлөлтэй хийсэн уулзалтын зөвшөөрлийг 2025 оны 05 дугаар сарын 1/651 албан бичгээр хүссэн. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шинжаан Уйгурын Өөртөө Засах Орны Цонж Хүй аймагт зохион байгуулагдсан Шинжааны соёлын наадамд аймгийн Засаг дарга Г.Чинбатаар ахлуулсан бүрэлдэхүүн 2025 оны 08 дугаар сарын 14-18-ны өдрүүдэд оролцсон. Айлчлалын зөвшөөрлийг 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 01/1091 тоот албан бичгээр хүссэн. 2025 оны 09 дүгээр сарын 12-15-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шинжаан Уйгарын Өөртөө Засах Орны Хами аймгийн намын дарга Сун Таотай хийсэн уулзалтын зөвшөөрөл, ярианы сэдвийн чиглэлийг 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 02/1197 дугаар албан бичгээр авч, уулзалтын тэмдэглэл, илтгэх хуудсыг 2025-09-19	100
--	--	--	---	---	---------------	--	-----

						өдрийн 01/1289 албан бичгээр ГХЯ-ны Бодлогын газарт хүргүүлсэн.	
1.7.2	Аймгийн 2024 оны гадаад хамтын ажиллагааны тухай тайланг, 2025 оны төлөвлөгөөний хамт Гадаад харилцааны яаманд хүргүүлнэ.		Тайлангийн тоо	1	1	Аймгийн гадаад хамтын ажиллагааны 2024 оны тайлан, аймгийн 2025 оны гадаад арга хэмжээний 5 зорилт, 16 заалт бүхий төлөвлөгөөг аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталж, Гадаад харилцааны яаманд тус тус хүргүүлнэ.	100
Зорилт 1.8. Уламжлалт найрсгаг харилцаатай улс, орнуудтай харилцааг бататган хөгжүүлж, өндөр хөгжилтэй улс, орны хот, мужуудтай шинээр харилцаа тогтоох, хөрөнгө оруулалт татах арга хэмжээг зохион байгуулна.							
1.8.1	БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орон, Ганьсу муж, ШУӨЗО-ны аймгууд, Шинжаан дахь Вужячунь хоттой хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр албан хүсэлт, хүргүүлж, удирдах түвшний уулзалт зохион байгуулна.	-	Уулзалтын тоо	1	2-оос доошгүй	БНХАУ-ын Ганьсу муж, ӨМӨЗО, ШУӨЗО-ны Хами, Цонж, Алтай аймгуудтай орон нутгийн онцлог, давуу талд түшиглэн хил дагуух бүс нутгийн гадаад хамтын ажиллагааг идэвхижүүлэн, уламжлалт харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлж, гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, соёл, боловсрол, дэд бүтэц, байгаль орчны хамгаалал зэрэг олон салбарт хамтын ажиллагааг өргөжүүлж, хоёр улсын бүс нутгийн харилцан ашигтай түншлэлийг бий болгон ажиллаж байна. Мөн БНХАУ-ын эрчим хүчний төрийн өмчит компанийн төлөөлөл аймгийн удирдлагуудтай хийсэн	70

						уулзалт, 2025 оны 09 дүгээр сарын 12-15-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шинжаан Уйгарын Өөртөө Засах Орны Хами аймгийн намын дарга Сун Таотай хийсэн уулзалт, БНХАУ-аас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Шэнь Минь Жуань /2025.07.23/, Япон Улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Игавахара Масарү /2025.08.26/ уулзалт, нийт 5 уулзалтыг зохион байгууллаа.	
1.8.2	Өндөр хөгжилтэй болон бусад орны Засгийн газрын тэтгэлэгт урт болон богино хугацааны сургалтын талаар мэдээллийг хүргэж, зөвлөгөө өгнө.	-	Хүргэсэн зөвлөгөө, мэдээллийн тоо	5	4-өөс доошгүй	Тайлант онд 2025-2026 оны ГУСМ Ганьсу мужийн олон улсын оюутнуудад зориулсан элсэлтийн танилцуулгыг орчуулан бэлтгэж НБХ-ээр дамжуулан 12 дугаар анги төгсөгчдөд танилцуулсан. Мөн Ганьсу мужийн 2025 оны тэтгэлэгт богино хугацааны сургалт, Мэтью Гирвиний нэрэмжит оюутны тэтгэлэгт хөтөлбөр 2025-2026 зэрэг хөтөлбөрүүдийн танилцуулгыг хүргэж ажиллалаа. Ганьсу мужийн Ардын Засгийн газрын Гадаад Харилцааны Алба тус хөтөлбөрийг зохион байгуулдаг бөгөөд Ганьсу муж болон олон улсын түнш орнуудын эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан, технологи, боловсрол, соёлын салбар дахь хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх зорилготой "Ганьсу-2025 тэтгэлэгт хөтөлбөр"-ийн мэдээллийг орчуулж хүргэсэн. 2025-2026 оны "ГУСМ" Олон Улсын оюутнуудад зориулсан элсэлтийн танилцуулгыг орчуулан хүргэсэн. Мөн аймгаас БНХАУ-ын Ланьжөү хотын Технологийн их сургуулийн хэлний	100

						бэлтгэлд элсэн суралцагдад сургуулийн элсэлтийн материал, линк, журмыг орчуулан хүргэсэн.	
1.8.3	Боомтын сэргэлтийн дэд хорооны ажлын хүрээнд хилийн Нарансэвстэй-Мазушань боомтыг нээн ажиллуулах чиглэлээр ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй хамтран ажиллах	-	Боомттой холбоотой ажил арга хэмжээний тоо	3	4	Нарансэвстэй боомтыг сэргээж нээхтэй холбоотой шаардлагатай мэдээлэл цуглуулах, боловсруулах, нэгтгэх ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Энэ чиглэлээр 2 удаа шаардлагатай мэдээлэл цуглуулах, боловсруулах, нэгтгэх ажлын хэсэг боомт орчимд ажилласан. Мөн "Монголын системийн инженерчлэл загварчлал судалгааны төв" - тэй гэрээ байгуулан Нарансэвстэй боомтын эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөөг тооцсон загварчлалыг хийх ажлыг гүйцэтгэн хүлээн авсан.	70
1.8.4	Гадаадын төслийн байгууллагын хөрөнгө оруулалтаар сум, байгууллагуудад хийгдсэн төсөл, арга хэмжээний тайлан мэдээг хагас, бүтэн жилээр авч нэгтгэх	-	Тайлангийн тоо	2	2	Аймагт хэрэгжиж байгаа урт болон богино хугацаат 17 төсөл хөтөлбөр хэрэгжсэнээс хүүхэд хамгаалал, барилга байгууламж, хөдөө аж ахуй, эмнэлэгийн тоног төхөөрөмж, булаг усны хашаа хамгаалалт, сургалтын үйл ажиллагаа бүхий хөтөлбөрүүдийн жилийн тайланг гаргаж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийлтгэж ажиллалаа.	100
1.8.5	Аймгийн боомтын сэргэлтийн дэд хорооны 2025 оны ажлын төлөвлөгөөг гаргаж, ажлын гүйцэтгэлийг хагас, бүтэн жилээр тайлагнах;	-	Төлөвлөгөө, тайлангийн тоо	2	2	Бургастай боомтын бүтээн байгуулалтын ажлыг Хятад талын Ласемю боомтын бүтээн байгуулалт орц гарцтай уялдуулж зураг төслийг	70

						хийлгэхээр ажиллаж байна. Нарансэвстэй боомтыг сэргээж нээхтэй холбоотойгоор шаардлагатай мэдээлэл цуглуулах, боловсруулах, нэгтгэх ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.	
						Аймгийн боомтын сэргэлтийн дэд хорооны 2 дугаар хурлаар ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, Төлөвлөгөөнд орсон ажил арга хэмжээнүүдээс Нарансэвстэй боомтыг сэргээж нээхтэй холбоотой шаардлагатай мэдээлэл цуглуулах, боловсруулах, нэгтгэх ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Мөн Бургастай боомтын бүтээн байгуулалтын ажлыг Хятад талын Лаомяо боомтын бүтээн байгуулалт орц гарцтай уялдуулж зураг төслийг хийлгэх, Алтай-Бургастай чиглэлийн хатуу хучилттай зам, Алтай сум болон Бургастай боомт руу БНХАУ-ын ШУӨЗО-ны Хами аймгаас 35кВт-ын агаарын шугам татах зэрэг ажлууд хийгдэж байна.	
1.8.6	Гадаадын төсөл хөтөлбөрийн байгууллага, улс, муж, хот, аймгуудтай хийх гэрээ, санамж бичгийг ГХД-ны Гэрээ эрх зүйн газраар хянуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Гэрээ, санамж бичгийн тоо	2	2-оос доошгүй	"Тэрбум" мод тарих үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Ногоон сүлжээ" ТББ-тай хамтран орон нутгийн тогтвортой хөгжийг хангах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, газрын доройтлыг бууруулах, цөлжилтийг сааруулах чиглэлээр шинжлэх ухааны мэдлэг, судалгааны үр дүн, туршилт арга зүйд суурилсан олон талт судалгааны төсөлт ажлыг	100

						хэрэгжүүлэхтэй холбоотойгоор санамж бичиг, Мөн БНХАУ-ын ШУӨЗО-ны Цонж аймгийн хошуудтай сумдыг хамтын ажиллагаатай болгох төлөвлөгөөний төслүүдийг тус тус хянуулж, чиглэл хариуг мөрдөн ажиллаа.	
Зорилт 1.9. Дипломат болон албан паспорт олгох тухай журмын хэрэгжилтийг хангаж ажиллах							
1.9.1	Дипломат болон албан паспорт олгох тухай журмын дагуу эзэмших эрх бүхий албан хаагчид эзэмшүүлэх ажлыг зохион байгуулж, тайланг Консулын газарт хүргүүлнэ.	-	Олгосон паспортын тоо	3	-	Тайлант онд аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарын гэр бүл дипломат паспорт - 4, аймгийн Засаг даргын орлогч, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Есөнбулаг сумын Засаг даргын орлогч, аймгийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн нарт албан паспорт – 4 тус тус мэдүүлж, Гадаад харилцааны Яамны Консулын газар олголт хийсэн.	100
1.9.2	Ажлаас чөлөөлөгдсөн хүмүүсийн дипломат, албан паспорттыг хураан авч Гадаад харилцааны яамны Консулын газраар хүчингүй болгуулах ажлыг зохион байгуулна.	-	Хүчингүй болгосон паспортын тоо	1	-	Тайлант онд дипломат, албан паспорт эзэмшигч албан тушаалтан ажлаас чөлөөлөгдөөгүй болно.	100
Зорилт 1.10. Орон нутгийн удирдлага зохион байгуулалтаар хангаж, төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын талаар төрөөс баримтлах бодлого, шийдвэрийг хэрэгжүүлнэ.							
1.10.1	Аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хурлын бэлтгэл, зохион байгуулалтыг хангаж, тэмдэглэл үйлдэн, шийдвэрүүдийг хэрэгжүүлэхэд хэлтсүүдийн оролцоог хангуулна.	-	Зохион байгуулагдсан хурлын тоо	30	25-аас доошгүй	Аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 30 удаагийн хуралдааны үйл ажиллагааг зохион байгуулж, тэмдэглэл хөтлөн, хуралдааны тэмдэглэлээс 209 баримт бичиг олголоо.	100
1.10.2	Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн дарга нарын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, хянаж, баталгаажуулж хэрэгжилтийг хангуулахад хяналт хийж зөвлөмж өгөжиглэх	-	Агентлагийн тоо	24	24	Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 24 агентлагийн дарга нарын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, хянаж, баталгаажуулж хэрэгжилтийг	100

						хангуулахад хяналт тавин ажиллаж байна.	
1.10.3	Аймгийн Засаг дарга болон Сумын Засаг даргын хооронд төрийн зарим чиг үүргийг 2025 онд орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг байтгаж, баталгаажуулан гүйцэтгэлд хяналт үнэлгээ хийлгэхэд хамтран ажиллах	-	Сумдын тоо	18	18	Аймгийн Засаг дарга болон 18 сумын Засаг даргын хооронд төрийн зарим чиг үүргийг 2025 онд орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг байтгаж, баталгаажуулан гүйцэтгэлд хяналт тавин үнэлгээ хийж ажиллалаа.	100
1.10.4	Байгууллагын дарга нарын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, хянаж, баталгаажуулан гүйцэтгэлийг хангуулах	-	Байгууллагын тоо	12	12	Байгууллагын дарга нарын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, хянаж, баталгаажуулан гүйцэтгэлийг хангуулан ажиллаж байна. Аймгийн Засаг даргын 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/607 дугаар захирамжийн 3 дугаар хавсралтын дагуу 2025 оны 12 дугаар сарын 15-ны дотор хүлээн авч дүгнэж ажиллана.	100
1.10.5	Аймгийн төвийн албан байгууллагуудын дарга, эрхлэгч нарын шуурхай хурлыг долоо хоног бүр зохион байгуулж, үр нөлөөг сайжруулахад анхаарах	-	Зохион байгуулсан шуурхай хурлын тоо	37	35-аас доошгүй	Аймгийн төвийн албан байгууллагуудын дарга, эрхлэгч нарын шуурхай хурлыг долоо хоног бүр нийт 26 удаа зохион байгуулж, хурлаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.	100
1.10.6	Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад анхаарч, "Нээлттэй хаалганы өдөрлөг" арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж, тайланг нэгтгэн ЗГХЭГ-т хүргүүлэх	-	Оролцсон байгууллагын тоо	86	86	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд Баян-Уул, Хөхморьт, Дарив, сумдын малчин иргэдэд зориулж Хүйсийн говь багийн нутаг "Өвгөр шар" газарт аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллагууд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж ажиллалаа. Мөн "Нээлттэй засаглалын түншлэг"-ийн арга хэмжээг зохион байгуулж тайланг Засгийн газрын хэрэг Эрхлэх газар potinshimed@ncsr.gov.mn цахим хаягаар тайлагнаж ажиллалаа.	100

1.10.7	Аймгийн Засаг дарга болон сумын Засаг даргын хооронд төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний биелэлтэд үнэлэлт дүгнэлт өгөх;	-	Гэрээ дүгнэсэн сумын тоо	18	18	Аймгийн Засаг дарга болон сумын Засаг даргын хооронд төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний биелэлтийг аймгийн Засаг даргын 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/607 дугаар захирамжийн 3 дугаар хавсралтын дагуу 12 дугаар сарын 31-нд хүлээн авч дүгнэж ажиллана.	100
Зорилт 1.11. Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран ажиллах, цаг үеийн бодит мэдээ мэдээллийг бэлтгэн олон нийтэд шуурхай хүргэнэ.							
1.11.1	Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан, хяналт тавьж, биелэлтийг нэгтгэн, тайланг авч үнэлэлт дүгнэлт өгөх	ОНТ	Хамтран ажиллах гэрээний тоо	3	3-аас доошгүй	Орон нутгийн иргэдэд мэдээ мэдээллийг шуурхай хүргэх зорилгоор "Миний Алтай", "Алтай телевиз", "Алтайн мэдээ агентлаг"-уудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, аймгийн удирдлагын үйл ажиллагааг орон нутгийн сувгаар тогтмол мэдээллэв. "Улаанбаатар телевиз" ХК (UBS)-тай гэрээ байгуулж, "UBS 21 News" сувгаар дамжуулан улсын хэмжээнд Говь-Алтай аймгийн бодлого, арга хэмжээг сурталчилж, мэдээллийн хүртээмжийг өргөжүүлсэн. "Дайчин Сүбээдэй" ХК-тай 2025 оны 5-р сараас хамтран ажиллаж эхэлсэн бөгөөд Subeedei.mn цахим болон фейсбүүк хуудсаар дамжуулан бүтээлч, шинэлэг контентоор мэдээллийг олон нийтэд хүргэж байна. Говь-Алтай аймгийн баяр наадмын үйл ажиллагааг олон нийтэд шуурхай дамжуулах ажлын хүрээнд орон нутгийн Миний Алтай, Алтай телевиз, Алтайн мэдээ агентлагтай гэрээ байгуулан шууд дамжуулалт, сурвалжилга мэдээллийг хүргүүлэн ажиллалаа. 2025оны 09 дүгээр сарын 04-06-ны өдрүүдэд зохион	100

						байгуулагдсан "Алтайн Алтан намар"- 2025 арга хэмжээг сурталчлан таниулах зорилгоор Зариг.мн сайтай гэрээ байгуулан хамтран ажиллаж сурвалжилга мэдээг орон даар хүргэлээ. 2025 оны 08 сард 4 дэх жилдээ зохион байгуулагдсан Жантар залуучуудын фестивалийг сурталчлах, мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгоор Ховд.мн сайт, Мэдээллийн гүүр НҮТББ-тэй гэрээ байгуулан хамтран ажиллагаа.	
1.11.2	Аймаг орон нутгийн цаг үеийн мэдээ мэдээллийг тогтмол, шуурхай иргэд олон нийтэд мэдээлэх, сурталчилах	-	Мэдээллийн тоо	350	400-аас доошгүй	Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан ёсны фейсбүүк хуудсаар дамжуулан нийт 693 удаагийн мэдээлэл, мэдээ, контент нийтэлж, төрийн мэдээллийг олон нийтэд тасралтгүй хүргэв. 2025 оны байдлаар нийт 679 удаагийн мэдээ мэдээллийг нийтэлж аймаг, орон нутгийн цаг үеийн мэдээ мэдээллийг тогтмол, шуурхай иргэд олон нийтэд сурталчлан ажиллаж байна. Мөн 18 сумын Засаг даргын тамгын газрын хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтнүүдийг нэгтгэн шинэ мэдээ ,мэдээллийг тамгын газрын болон сумдын фейсбүүк хуудсаар нь дамжуулан ард иргэдэд хүргэн ажиллаж байна.	100
1.11.3	Аймгийн Засаг даргын илтгэл, мэдээлэл, цахим танилцуулга, судалгаа, шагнал үнэмлэх болон бусад шаардлагатай хэвлэлийн эх бэлтгэх, хэвлэх, цахим архив үүсгэх	ОНТ	Эх бэлтгэл, мэдээллийн тоо	40	50-аас доошгүй	Засаг даргын илтгэл, танилцуулгын загвар, Засаг дарга, ЗДТГ-ын үйл ажиллагаатай холбоотой дэлгэцийн баннер, постер, контент, Засаг даргын Жуух, үнэмлэх зэрэг 150 эх, бэлтгэл,	100

						хэвлэх материалын ажлыг гүйцэтгэж, цахим архив үүсгэн ажилласан байна.	
Зорилт 1.12. Төсөв, санхүүгийн чиглэлээр							
1.12.1	Байгууллагын төсөв, хөрөнгө санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах	-	Хэрэгжилтийн хувь	100	100	6,337,491,3 төгрөгийн санхүүжилт авч, зардал тус бүрээр зарцуулан үйл ажиллагаагаа явуулж байна. Сар бүр гаргадаг тайлан мэдээгээ цаг тухайд нь гарган ажиллаж байна.	100
1.12.2	Байгууллагын өдөр тутмын бэлэн ба бэлэн бус гүйлгээг хийж, харилцах дансны хуулга боловсруулан нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг сайжруулж, зөрчилгүй ажиллана.	-	Хэрэгжилтийн хувь	100	100	Байгууллагын өдөр тутмын бэлэн ба бэлэн бус гүйлгээг хийж, харилцах дансны хуулга боловсруулан сар бүр хуулга боловсруулан баримтаа сар бүр үдэн цэгцэлж ажиллаж байна.	100
1.12.3	Өмч хамгаалах байнгын зөвлөлтэй хамтран эд хөрөнгийн тооллогыг журмын дагуу гүйцэтгэх, тайлангах	-	Тооллого, тайлангийн тоо	2	2	Эд хөрөнгийн хагас жилийн тооллогыг Тамгын даргын А/45 тушаалаар 06 дугаар сарын 18-ны өдрөөс 25-ны өдрүүдэд хооронд журмын дагуу гүйцэтгэсэн. Мөн жилийн эцсийн тооллогыг 12.15-аас 12.23-ны хооронд хийхээр төлөвлөн ажиллаж байна.	100
Зорилт 1.13. Архив, албан хэрэг хөтлөлт чиглэлээр							
1.13.1	Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийг зохих хууль журмын дагуу зохион байгуулж, шилжүүлж ажиллах	-	Хэрэгжилтийн хувь	100	100	Байгууллагын хэмжээнд 2025 онд 736 захирамж, 201 тушаал, 3 албан даалгавар, 1647 албан бичиг зохих журмын дагуу хэвлэмэл хуудсан дээр буулгаж, 3755 албан бичиг хүлээн авч, бүртгэн шилжүүлж ажиллаа. Архив, албан хэрэг хөтлөлтийн шинэчлэгдсэн журмын дагуу бүртгэл тайлангаа шинэчилсэн. Мөн бичиг хэргийн ажилтнууд "Архив, албан хэрэг хариуцсан ажилтны чадавхжуулах сургалт"-д хамрагдаж сертификат авсан. 11 нэр төрлийн албан бичгийг	100

						хос бичгээр хөтөлж байна. Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт хамрагдаж 94,6 хувьтай сайн үнэлэгдлээ.	
1.13.2	Хариутай бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж, хугацаа хэтэрсэн хариутай бичгийн мэдээг 7 хоног бүр удирдлагад танилцуулан шийдвэрлүүлж ажиллах	-	Шийдвэрлэлтийн хувь	100	90 хувиас доошгүй	Хариутай бичигт бүртгэл хяналтын карт хөтөлж сар болгон тайлан гаргаж хяналт шинжилгээ үнэлгээ хийлгэж ажиллаа. Хагас жилийн байдлаар 220 хариутай бичиг бүртгэж, хяналт тавин цаг тухай бүр хариу өгсөн.	100
1.13.3	Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, баримт хүлээн авах хуваарийг батлуулж, хүлээн авах, бүртгэл үйлдэн эзэнжүүлж ажиллах	-	Хуваарийн дагуу хүлээн авсан баримтын тоо	70жил4 3 ХН Байнга 119Н Түр 207 ХН	70жил 43 ХН Байнга119ХН Түр 207 ХН	Аймгийн ЗДТГ-ын 2025 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалт архивын баримтыг 2024 оны 03 сарын 01-25-ны өдрүүдэд ТЗУХ, ХБТХОХ, ХЭЗХ, СТСХ, ХШҮХ, НБХ Төрийн албаны салбар зөвлөл, албан хаагчийн нараас 369 хадгаламжийн нэргийг хүлээн авч байнга 119 ХН, Түр 207 ХН, 70 жил хадгалагдах 43 ХН-ийг данс бүртгэл хийж бүртгэлжүүлээ.-ТЗУХ, ХБТХОХ, ХЭЗХ, СТСХ, ХШҮХ, НБХ-ийн мэргэжилтнүүд тус бүрээс архивын баримт хүлээлгэн өгөх жагсаалтын дагуу хүлээн авч бүртгэлийг 2017-2024 оны байнга 760 ХН, түр 2023-2024 оны түр хадгаламжийн 496 ХН, 70 жил хадгалагдах 139 ХН нэгжүүдийн бүртгэлийг тус бүр хийж бүртгэл үүсгэж, дугаарлалт, хайрцагт хийж, хадгалалт хамгаалалтыг сайжруулж ажиллаа. АЗТГ-ын байнга хадгалагдах нэгжнүүдийг архивын хуучин өрөөнөөс архивын шинэ өрөөнд зөөж тавиурт байрлуулж тавьж ажилласан. Өмнөх архивын ажилтан байнга хадгалагдах 2015-2022, түр	90

						хадгалагдах 2007-2022, 70 жил хадгалагдах хадгаламжийн 1972-2022 онуудын баримтнууддаа дугаарын давхардал үүсгэж мөн төрийн архивын баримтнуудыг янзлах нөхцөл байдлтай үлдээж хүндрэл үүсгэж, эхнээс байнга, 70 жилийн хадгаламжийн нэгжнүүдийг эхнээс цэгцэлж ажиллаж байгаа болно. Архивын ерөнхий газраас шалгалтыг ирэхийг тохиолдуулан Аймгийн Төрийн архивын хэлтэст хадгалагдаж буй аймгийн ЗДТГ-ын байнга хадгалагдах 1992-2016 оны бүх баримтнуудад нөхөн бүрдүүлэлт хийж үүрэг даалгавар өгсөний дагуу 1992-2002 оны 60 баримтнуудыг товчоог бичиж, 75 баримтыг үдэж хавтаслаж ажиллалаа. 900 хадгаламжийн нэгжийн хадгалалт хамгаалалт хийх шаардлагатай болон хуучирч муудсан баримтнуудыг шинээр сольж, 300 ш шинэ хайрцагийг сольж хадгалалт хамгаалалтыг сайжруулж ажиллалаа 2025 оны 01 дүгээр улиралд 55 иргэн болон албан хаагч нарт архивын лавлагаа олгож, хуулбарлан тухай бүр ERP болон facebook хаягаар хүлээлгэн нийт 60 хадгаламжийн нэгжнээс шүүн өгч ажиллаа. Аймгийн Прокурор, аймгийн Цагдаагийн газруудад хуулбар үнэн болон хялбаршуулсан хэргийн баримтнуудыг хүлээлгэн өгч, хүлээн авч ажилласан.	
--	--	--	--	--	--	--	--

						2012-2023 оны Б тушаал 13 ш , 2012-2022 оны А тушаал 11 ш, тус тус скайнердаж үдэж хавтаслаж, архивын программд оруулахад бэлэн болгосон. ХШҮХ-ийн НБХ-үүдийн 2024 оны цахим архивыг хүлээн авч, байгаа цахим баримтуудаас хайлт хийж, иргэд, төрийн албан хаагч нарт цахмаар үйлчилэхэд болгон ажилалаа.	
1.13.4	Хадгаламжийн нэгжид тооллого хийж, цахим дэлгэрэнгүй бүртгэлтэй болгон ашиглалтыг сайжруулах	-	Тооллогын тоо	-	1	-Архивын ерөнхий газрын 2025 оны 10 дугаар сарын 01-10-ны өдрүүдэд Говь-Алтай аймгийн төрийн байгууллага болон сумдын төрийн байгууллагад архив албан хэрэг хөтлөлтөд шалгалт хийх албан бичиг удирдамжийн дагуу ЗДТГ-ын архивт хадгалагдах архивын баримтнуудыг 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн байнга 760 ХН, 70 жилийн 139 ХН-ийн бүртгэлийг шинээр хийж, түр хадгалагдах 496 ХН-ийн 2023-2024 оны баримтнуудыг шинээр эхлэж тус тус шинээр бүртгэл үүсгэж ажиллаа. Түр хадгалагдах хадгаламжийн нэгжнүүд нь он он дээр дугаарын давхардал ихтэй бөгөөд 2007-2024 онуудын баримтнуудыг шинээр бүртгэл хийх тул ажлын цаг заваараа архивын баримтнууддаа янзлаж ажиллаж байна.	90
Зорилт 1.14. Байгууллагын дотоод ажлыг хариуцан зохион байгуулах ажлын хүрээнд							
1.14.1	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, батлуулах	-	Батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө	1	1	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, батлуулж ажиллалаа.	100

						/2025 оны 7 сараас хойш уг ажил БОНХОБТХ-т чиг үүргийн дагуу шилжсэн/	
1.14.2	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэн тайлагнаж, ХШҮХ-д хүргүүлэх	-	Тайлагналтын тоо	1	1	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэн тайлагнаж, ХШҮХ-д хүргүүлж ажиллалаа. /2025 оны 7 сараас хойш уг ажил БОНХОБТХ-т чиг үүргийн дагуу шилжсэн/	100
1.14.3	Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, батлуулах	-	Батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө	1	1	Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, батлуулж ажиллалаа.	100
1.14.4	Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж, ХШҮХ-д хүргүүлэх	-	Тайлагналтын тоо	2	2	Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж, ХШҮХ-д хүргүүлж ажиллалаа.	100
1.14.5	Байгууллагын албан хаагчдын хурлын тэмдэглэл хөтлөх	-	Хурлын тоо	4	4	Байгууллагын албан хаагчдын хурлын 3 тэмдэглэлийг хөтөлж албажуулан ажиллалаа.	100
1.14.6	Хэлтсийн дарга нарын хурлын тэмдэглэл хөтлөх	-	Хурлын тоо	22	22-оос доошгүй	Хэлтсийн дарга нарын хурлын 3 тэмдэглэлийг албажуулан ажиллалаа.	100
1.14.7	Хэлтсийн сарын ажлын хуваарь гарган, хэрэгжилтийг хангуулах	-	Хэрэгжилтийн хувь	100		Хэлтсийн сарын ажлын хуваарь гарган, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс 2025 оны 09-10 дугаар сарыг хэлтсийн сарын ажлыг зохион байгуулсан. Бусад хэлтэс бүр тодорхой ажлуудыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, хамт олныг идэвхжүүлэх ажлуудыг гүйцэтгэж байна.	100
ХОЁР. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ							
Зорилт 2.1. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайлалаар хангах							
2.1.1	Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг, нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын	-	Мэдүүлэг, Мэдэгдэл, тайлбарын тоо	2	3-аас доошгүй	Хэлтсийн дарга, Төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, ахлах мэргэжилтэн 3 албан	100

	зөрчилгүй мэдэгдлийг цаг тухай бүрт тайлагнах					тушаалтан хуулийн хугацаанд хөрөнгө орлогын мэдүүлгийг мэдүүлсэн.	
2.1.2	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримтуудыг цаасан, цахим байдлаар хүлээлгэн өгөх	-	Хүлээлгэн өгсөн хадгаламжийн нэгжийн тоо			Аймгийн ЗДТГ-ын 2025 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалт архивын баримтыг 2025 оны 03 сарын 01-25-ны өдрүүдэд 180 ш хадгаламжийн нэгжийг хүлээн авлаа	100
2.1.3	Сар бүрийн тайланг заасан хугацаанд холбогдох хэлтэст гаргаж хүргүүлэх		Тайлангийн тоо	12	12	Бүх ажилтан, албан хаагчид сар бүр тайлангаа мэргэжилтэн Л.Нямбаярт өгч хэвшсэн.	90
2.1.4	Хэлтсийн сарын ажил, арга хэмжээг албан хаагчдыг хамруулан үр дүнтэй зохион байгуулах, бусад хэлтсээс зохион байгуулсан үйл ажиллагаанд идэвхи, санаачлагатай оролцох		Зохион байгуулсан арга хэмжээний тоо	5	5-аас доошгүй	Сарын ажлын хүрээнд зохиогдож байгаа арга хэмжээнүүдэд хэлтсийн албан хаагчид идэвхи, санаачлагатай оролцлоо.	100
2.2. Систем хөгжүүлж, мэдээллийн сан бүрдүүлж иргэдийг мэдээллээр хангах							
2.2.1	Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь оруулах, ил тод байдлыг хангах, хуулийн хугацаанд тайлагнах	-	Мэдээллийн тоо	159	159	Шилэн Дансны тухай хуульд заасны дагуу хугацаанд нь бүх мэдээллээ шивж, баримтаа сайнардан оруулж хэвшсэн.	100
ГУРАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ							
Зорилт 3.1 Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээг уяалдуулан төлөвлөрүүлж, иргэн аж ахуй нэгж байгууллагад төрийн үйлчилгээг нэг цэгээс ил тод, түргэн шуурхай хүргэн ажиллаж төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.							
3.1.1	Төрийн үйлчилгээний шат дамжлагыг цөөрүүлэн, үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор “Цахим Алтай” арга хэмжээ хэрэгжүүлж, үйлчилгээний нэгдсэн төвөөр үзүүлэх үйлчилгээний тоо, төрлийг нэмэгдүүлнэ.	-	Үйлчилгээ үзүүлж буй байгууллага, үйлчилгээний тоо	7 байгууллага, 158 төрлийн үйлчилгээ	6 байгууллага, 140 төрлийн үйлчилгээ	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор shien.gov.mn сайтад аймгийн 200 байгууллага бүртгүүлэхээс 196 байгууллага, гов.тп нэгдсэн системд 48 албан байгууллагуудын бүртгэлийг үүсгэж, бүртгэлийг баталгаажуулан хандах эрхийг нээн өгч, заавар зөвлөмж өгч ажиллаж байна. Аймгийн Засаг дарга болон ЦХИХХ-ны яамны сайдтай байгуулсан гэрээний хүрээнд аймгийн хэмжээнд 22 киоск (Аймгийн төвд-3, Сумдуудад-18)	100

						машин байршуулсан бөгөөд эхний 12 сарын байдлаар 10357 лавлагаа, мэдээлэл, тодорхойлолт гарсан байна.	
3.1.2	Ер.emonqolia.mn системийн нэвтрэлт, ашиглалтыг бүрэн хэрэгжүүлж, цагийн бүртгэлээр цалингийн тооцоо хийж хэвшүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах	-	Цагийн бүртгэлээр цалин тооцсон сарын тоо	-	10	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа хэрэгжүүлж буй 51-н төрийн байгууллалтыг ер.е-монqolia нэгдсэн системд бүртгэж, ашиглах заавар зөвлөгөө өгч үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж байна. Цалин хөлсийг цаг бүртгэлийн нэгдсэн системийн дагуу сар бүр тооцож олгож байна.	100

4. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

		-		-	2-оос доошгүй	Удирдлагын академийн орон нутаг хариуцсан менежерүүдэд зориулсан сургалт 01 дүгээр сарын 09,10-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулагдсан сургалтад хамрагдсан. Гадаад харилцааны яамнаас 21 аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлага, албан хаагч нарт зориулсан сургалт 2025 оны нэгдүгээр сарын 15-нд хамрагдсан. БНХАУ-ын Засгийн газар, Худалдааны яамнаас зохион байгуулсан Төрийн удирдлагын академийн сургалтанд 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 2025 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хооронд 21 хоног хамрагдсан.	100
1.	Хариуцсан чиг үүргийн хүрээнд зохион байгуулагдах сургалт, уулзалт, хэлэлцүүлэгт хамрагдах		Хамрагдсан сургалт, уулзалтын тоо				
2	Удирдлагын манлайлал чиглэлээр сургалтад хамрагдах	-	Суралцаж төгссөн сертификат	-	1	Жендэрийн Үндэсний Хорооноос санаачлан гуравдах буй "Азийн хэрэгжүүлж	100

						эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр"-ийн энэ удаагийн сургалтыг Азийн хөгжлийн банктай хамтран зохион байгуулж байгаа ба сургалтад 21 аймгийн удирдах албан тушаалд ажиллаж буй 25 эмэгтэй хамрагдсан.	
3	Үндэсний бичгийн мэдлэг чадвараа сайжруулах, компьютерын цэс суулгаж албан хэрэгцээндээ ашиглаж хэвших	-	Ашиглаж хэвшсэн эсэх	-	1	Үндэсний бичгээр унших, бичих чадвараа нэмэгдүүлэн бие даан суралцаж албан хэрэгцээндээ тогтмол ашиглаж байна.	90
ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ							96.5

Төлөөлөгөөс үнэлсэн:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
(албан тушаал)

Төсвийн шууд захирагч

..... /Ш.ЭРДЭНЭБАТ/
(гарын үсэг) (албан хаагчийн нэр)

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

Нэгжийн дарга:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

.....
(гарын үсэг)

Я.ЖАРГАЛЦЭЦЭГ
(албан хаагчийн нэр)

.....
(огноо)